

**ЗАСГИЙН ГАЗРЫН ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

№	Үндэслэж байгаа стратеги төлөвлөгөө, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв /мян төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин (хэрэгжилт болон тайлбар)	Гүйцэтгэлийн хувь
1. СОЁЛЫН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, ЦАХИМ ШИЛЖИЛТИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР							
1.1	Соёлын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх	Улсын болон орон нутгийн төсөв	Хөнгөлөлт тэй нөхцөлөөр сургасан, нийгмийн баталгаа үзүүлсэн дэмжлэгийн тоо	2023 онд цахим болон танхимаар зохион байгуулсан 5 сургалтад 216 соёлын ажилтныг хамруулсан	Хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр өмнөх оны хүрсэн түвшнийг бууруулаагүй байх, соёлын ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлсэн байна	<p>Аймгийн Засаг дарга соёлын салбарын 65 ажилтан, албан хаагч, уран бүтээлчтэй уулзаж тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замыг хэлэлцлээ. Уулзалтын үр дүнд Төв номын сангийн уншлагын танхимд 6,6 сая төгрөгөөр агаар цэвэршүүлэгч, Музей сургалт судалгааны төвд “Музейтэй Дорноговь” аяныг зохион байгуулхад 6,9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн.</p> <p>Хагас жилийн байдлаар албан хаагчдыг чадавхжуулах 31 сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор салбарын 264 ажилтанд төрийн бодлого шийдвэр, салбар дундын хамтын ажиллагаа, хууль тогтоомж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хүний нөөцийн чадавхийг бэхжүүллээ. Сургалт, арга хэмжээнд аймаг орон нутгаас 10,0 сая төгрөг зарцуулсан. /тахимаар-13, цахимаар-18/</p> <p>Хүний нөөцийн сул орон тоог нөхөх, мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор СУИС-д хөгжмийн багш мэргэжлээр суралцдаг 5, хөгжимчнөөр суралцдаг 4 оюутанд орон нутгаас сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлж, орон нутагтаа ажиллуулах гэрээ байгууллаа.</p> <p>Салбарын албан хаагчдын нийгмийн баталгаа сургалтын хөтөлбөрийг 4 зорилт, 22 арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэн ажиллалаа.</p> <p>Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалан чиглэлээр аймгийн Соёл, урлагийн газар албан хаагчдад эрүүл мэндийн зөвлөгөө өгч, өдрийн эмчилгээ, сувилгаа болон элэгний В, С вирусын түргэвчилсэн шинжилгээнд</p>	90

						<p>хамруулж, уламжлалт рашаан сувилалд амраахад дэмжлэг үзүүлэн цалинтай чөлөө олгосон.</p> <p>Идэвхтэй хөдөлгөөнийг тогтмолжуулах зорилгоор спортын 5 төрөлт тэмцээнд салбарын 180, фитнес, йога, спортын дугуйланд 80 гаруй ажилчид, албан хаагчид, уран бүтээлчид хамрагдсан.</p> <p>Соёлын салбарын 33 албан хаагчийг төрийн дээд шагнал болон салбарын шагналд тодорхойлж, урамшуулан, 32 албан хаагчийг туршлага судлуулсан.</p> <p>Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах зорилтыг хэрэгжилтийн хүрээнд 5 жил тасралтгүй ажилласан соёлын салбарын 3 албан хаагчид 26,3 сая төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон.</p> <p>Салбарын албан хаагчдын нийгмийн баталгаа сургалтын хөтөлбөр 50%-тай хэрэгжсэн.</p>	
1.2	<p>Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоол шинэ сэргэлтийн бодлого 4.2</p> <p>Соёл урлагийн байгууллагуудад шилжин суурьшин ажиллах иргэдийг бодлогоор дэмжих</p>	Орон нутгийн төсөв	Орон нутагт шилжин суурьшихад дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоо /орон сууц бусад/	2023 онд 9 соёлын ажилтныг орон сууц, ажиллах нөхцөлөөр хангасан	Орон нутгийн соёлын байгууллагад хотоос шилжин суурьшиж ажиллах иргэдэд дэмжлэг үзүүлсэн байна	Улаанбаатар хотоос орон нутагт шилжин ажиллахаар ирсэн “Саран хөхөө” театрын 4 албан хаагч, сумдын соёлын төвийн 5 албан хаагчид амьдрах орон сууц, орон нутгийн нэмэгдэл, хоолны хөнгөлөлт үзүүлэн ажлын байрны таатай орчинг бүрдүүлэн дэмжиж ажиллалаа.	90
1.3	“Цахим соёл” арга хэмжээний хүрээнд хөгжүүлсэн Creativhub-ийг нэвтрүүлж чөлөөт уран бүтээлч болон байгууллагыг бүртгэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах	ОНТ УТ	Бүртгэлд хамруулсан уран бүтээлчдийн тоо	Creativehub цахим системийн хөгжүүлэлт хийгдсэн.	50-аас доошгүй уран бүтээлчдийг хамруулсан байна.	Соёлын яамнаас цахим системийн хөгжүүлэлт хийгдэж дуусахаар чөлөөт уран бүтээлчид, байгууллагыг дэмжин ажиллана.	Х.Б
1.4	“Цахим соёл” арга хэмжээний хүрээнд хөгжүүлсэн /номын сан, соёлын өв, GLAM, портал сайт/ системүүдийг орон		Мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээллийн хувь	Номын сан, соёлын өв, GLAM, портал сайт цахим	Номын сан, соёлын өв, уран бүтээлийн бүртгэл мэдээллийн	Соёлын яамнаас цахим системийн хөгжүүлэлт хийгдэж	Х.Б

	нутагтаа нэвтрүүлж хэрэгжилтийг хангах	ОНТ		системийн хөгжүүлэлт хийгдсэн	санг 25 хувьд хүргэнэ. Салбарын портал сайт ашиглалтыг тогтмол, тасралтгүй хэрэгжүүлсэн байна.	дуусахаар системүүдийг орон нутагтаа нэвтрүүлж хэрэгжилтийг хангана.	
1.5	Соёлын салбарын статистикийн мэдээ, тайланг батлагдсан маягтын дагуу өмчийн бүх хэлбэрийн соёл, урлагийн байгууллагуудаас цуглуулж, үнэн зөв, бодитой гаргаж ирүүлэх.	-	Бүртгэлийн болон захиргааны статистикийн маягтаар гаргасан тайлангийн тоо	2023 оны үйл ажиллагааны тайлан, ажиллагсдын статистик 11 мэдээ -Хөрөнгө, санхүүгийн мэдээ	Бүртгэлийн статистикийн 11, захиргааны статистикийн 12 маягтаар гаргасан тайлангийн тоо	<p>Статистик мэдээ гаргах цахим сургалтыг соёлын салбарын 22 албан хаагчийг хамруулан зохион байгуулж арга зүйн зөвлөгөө өгсөн.</p> <p>Боловсрол Шинжлэх Ухааны Сайдын 2020 оны А/181 дүгээр тушаалаар батлагдсан маягтын дагуу төрийн өмчийн-17, хувийн хэвшлийн-1, нийт 18 байгууллагаас 2023 оны соёл, урлагийн салбарын статистик мэдээг хуулийн хугацаанд хүлээн авч, хянасан.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайдын 2021 оны 12 сарын 15-ны өдрийн А/300 дугаар тушаалаар баталсан улирлын мэдээний маягтын дагуу Дорноговь аймгийн Соёл, урлагийн салбарын байгууллагуудын үйл ажиллагааны 1, 2 дугаар улирлын мэдээг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газарт хүргүүллээ.</p> <p>Бүртгэлийн статистикийн 11 маягтаас 9 маягтын дагуу, захиргааны статистикийн 12 маягтаар нэгтгэлийг гаргасан.</p>	100
2. СОЁЛЫН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР							
2.1	Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2.6.2.2 Соёлын сэргэлт-2024 арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж оролцох	ОНТ	Дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоо, зарцуулсан төсөв	Хөдөөгийн сэргэлт, шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд “Соёлын сэргэлт 2023” арга хэмжээг зохион байгуулсан	Орон нутгийн оролцоог хангаж оролцсон байна. Арга хэмжээнд дэмжлэг үзүүлж санхүүжүүлсэн байна.	<p>“Соёлын сэргэлт-2024” аяны хүрээнд зохион байгуулсан “Монгол гэр” үзэсгэлэнд орон нутгаа төлөөлөн оролцсон албан хаагч, уран бүтээлчдэд орон нутгаас 10,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Үзэсгэлэнг гадаад, дотоодын 10000 иргэн үзэж, боловсролын хөтөлбөрт 2000 гаруй хүүхэд багачууд хамрагдсан.</p> <p>Тус аяны хүрээнд зохион байгуулсан удирдах ажилтны зөвлөгөөнд оролцсон 20 албан хаагчид аймгийн Засаг даргын А/343 дугаар захирамжаар 3,5 сая төгрөгийн замын зардлын дэмжлэг үзүүлсэн.</p>	100

2.2	<p>Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.2</p> <p>Бүх нийтийн соёлын боловсрол арга хэмжээний төлөвлөгөө, “Нийгмийн харилцааны соёлыг дээшлүүлэх нөлөөллийн цогц ажлуудыг зохион байгуулах тухай” сайд нарын хамтарсан албан даалгаврын хэрэгжилтийг хангах</p>	ОНТ	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, нөлөөллийн аяны тоо	-	20-оос доошгүй арга хэмжээ 2-оос доошгүй нөлөөллийн аян зохион байгуулсан байна.	<p>Бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд соёлын салбарт хамаарах 17 заалтын хэрэгжилтийг ханган ажиллах тухай чиглэлийг аймгийн соёлын салбарын байгууллагуудад хүргүүлсэн.</p> <p>Соёлын боловсролыг дээшлүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд аймгийн Соёл, урлагийн газар, БШУГ хамтран сар бүрийн сүүлийн ажлын өдрийг “Соёлын өдөр” болгон зарласан. Үүний хүрээнд 9 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж 410 гаруй суралцагчдыг хамруулсан. Аймгийн төв талбайд зохион байгуулсан “Монгол гэр” соёлын орон зай хөтөлбөрт 21 төрлийн арга хэмжээг зохион байгуулж, 1000 гаруй иргэдийн нийгмийн харилцааны соёлыг дээшлүүлсэн.</p> <p>Бүх нийтийн соёлын боловсрол арга хэмжээний төлөвлөгөө, албан даалгаврын хэрэгжилт хагас жилийн байдлаар 90 хувьтай хэрэгжлээ.</p>	90
2.3	<p>Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.2</p> <p>Соёлын төвүүдэд түүхэн сэдэвт болон хүүхэд залуучуудад зориулсан кино гаргаж, кино урлагаар дамжуулан соёлын боловсрол олгох арга хэмжээг дэмжих</p>	ОНТ	Дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоо үзэгчдийн тоо	Үзэгчдийн тоо 600	2-оос доошгүй арга хэмжээнд дэмжлэг үзүүлж Үзэгчдийн тоо-2100	<p>Сумдын соёлын төвүүд хагас жилийн байдлаар 15 кино гаргаж, 800 гаруй иргэнд үзүүлсэн. Аймгийн “Gobi cinema” кино театр 32 кино гаргаж, 7044 иргэнд үйлчиллээ.</p> <p>Хагас жилийн байдлаар кино урлагаар дамжуулан 7844 иргэнд соёлын боловсрол олголоо.</p> <p>Кино урлагаар үйлчлүүлсэн иргэдийн тоо 2023 оноос 66,4%-иар өссөн.</p>	100
2.4	<p>Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл</p>	Орон нутгийн төсөв	Дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний	Дэмжлэг үзүүлсэн арга хэмжээ-2	2-оос доошгүй арга хэмжээнд дэмжлэг	<p>Жаргалан хүүхдийн зуслангийн үйл ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. “Зуслангийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх” удирдамжтай холбогдуулан хүүхдийн зусланд зохион</p>	30

	<p>ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.2</p> <p>Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хүүхдийн зусланд нүүдлийн ахуй соёл, уламжлалыг таниулах үйл ажиллагаа зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх</p>		тоо		үзүүлсэн байна.	байгуулах арга хэмжээний төлөвлөгөөнд нүүдлийн ахуй соёл, уламжлалыг таниулах үйл ажиллагааг тусгасан.	
2.5	<p>Соёлын тухай хуулийн 9.1.4, “ Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын Зорилт 1.4</p> <p>Түүх соёл, утга зохиол судлалын орон нутгийн судлаач зохиолчдыг дэмжих</p>	Орон нутгийн төсөв	Зохион байгуулсан арга хэмжээний тоо дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоо	Зохион байгуулсан арга хэмжээ- Дэмжлэг үзүүлсэн арга хэмжээ	3-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулж, дэмжлэг үзүүлсэн байна.	<p>Нутгийн яруу найрагч, хөгжмийн зохиолчдын дууг нутагшуулах, уран бүтээлийг сурталчлах, таниулах, дэмжин, хамтран ажиллах зорилгоор нутгийн 5 зохиолчийн бүтээлд 10,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Ноён хутагтын 220 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан “Ноён хутагтын өв: Өнгөрсөн, Одоо, Ирээдүй” ОУ эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийг эмхэтгэн хэвлүүлэх ажлыг дэмжиж, аймгийн Засаг даргын А/372 дугаар захирамжаар 5,0 сая төгрөг зарцуулсан.</p> <p>Саран хөхөө театр нутгийн уран бүтээлчдийн бүтээлийг сурталчлан, дэмжих зорилгоор “Түмэнд түгсэн дуун цадиг” тоглолтыг зохион байгуулж, танхимаар 300, цахимаар 4000 гаруй иргэнд толилуулсан.</p> <p>Соёл, урлагийн газар утга зохиол судлалын 2 судлаачийн бүтээлийг сурталчлан хэлэлцүүлэг зохион байгуулж 86 сурагчийг оролцуулсан.</p> <p>Хагас жилийн байдлаар орон нутгийн төсвөөс 9 судлаач, зохиолчийг дэмжин 15,0 сая төгрөг зарцуулсан.</p>	100
2.6	<p>Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.117, Номын сангийн тухай хуулийн 23.2, 24.4, БСШУСайдын 2018 оны А/683 дугаар тушаал, МУ-ын</p>	Бусад	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	2-оос доошгүй арга хэмжээнд дэмжлэг үзүүлсэн байх	<p>Аймгийн хэмжээнд 35 дах удаагийн “Үндэсний бичиг соёл, номын баяр-2024” арга хэмжээг “Илүү их уншъя” уриан дор 2024 оны 05 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд зохион байгууллаа.</p> <p>Номын баярын хүрээнд “Олуулаа уншъя” аян, орон нутгийн зохиолч, яруу найрагчдын уулзалт, шинэ номын нээлт зэрэг 22 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж 2250 гаруй иргэдийг хамруулсан нь өнгөрсөн оноос 1250 иргэнээр өссөн үзүүлэлттэй байна.</p>	100

	Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлиг “Номын баярын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, номоор дамжуулан иргэдийг соён гэгээрүүлэх олон талт ажлыг зохион байгуулах					Уг үйл ажиллагаанд нийт 3,3 сая төгрөг зарцууллаа.	
2.7	Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйл. Соёл урлагийн байгууллагын орчин ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлагын стандартыг хангахад дэмжлэг үзүүлэх	Орон нутгийн төсөв	Дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоо	-	3-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна	Соёл урлагийн байгууллагуудын орчин ба үйлчилгээний стандартын судалгааг Соёлын яаманд хүргүүлсэн. Аймгийн Музей сургалт судалгааны төвөөс Өргөн, Мандах суманд ажиллаж музейн үзмэр дэглэлт, стандартад арга зүйн зөвлөгөө өгч стандартыг мөрдүүлсэн. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Сайхандулаан сумын соёлын төвд 59,0 сая төгрөгөөр тоног төхөөрөмж, Даланжаргалан, Хатанбулаг сумдад 80,0 сая төгрөгөөр лед дэлгэц, Өргөн суманд 114,0 сая төгрөгөөр хөгжим, техник хэрэгслийг тус тус худалдан авч, үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн. Сайхандулаан сумын соёлын төвийг "Илч дулаан өсөх" компани 208,8 сая төгрөгөөр, Иххэт сумын соёлын төвийг "Чандмань тайж" ХХК 388,7 сая төгрөгөөр, Алтанширээ сумын соёлын төвийг "Мунараконстракшн" ХХК 451,9 сая төгрөгөөр их засварын ажлыг гүйцэтгэж, ажлын гүйцэтгэл 50%-тай явагдаж байна.	100
2.8	Соёлын тухай хуулийн 4.1.2, 14.2.1, Монгол хэлний тухай хуулийн 7.2,14.1.1, 17 дугаар зүйл, “ Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III” 3.2.15. “Үндэсний бичиг, соёлын жил-2024, “Эх хэлний өдрийг тэмдэглэн өнгөрүүлж, “Хос бичигтэн” аймаг уриалгыг гаргаж,	Бусад	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Үндэсний бичиг үсгийн бачр 2023, Эх хэлний өдөр 2023, “Хос бичигтэн байгууллага” арга хэмжээг хэрэгжүүлсэн.	10-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна.	Салбарын нийт байгууллагуудыг Үндэсний бичгийн булантай болох үүрэг чиглэл өгсний дагуу 7 сум “Үндэсний бичгийн булан” байгууллаа. Үндэсний бичиг соёлыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, иргэдийг соён гэгээрүүлэх зорилгоор “Үндэсний бичиг соёлын өдөр-2024” арга хэмжээний үеэр “Босоо бичиг-Бидний бахархал” Монгол бичгийн уран бичлэгийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж 27 багш, 23 сурагчийн бүтээлээс шилдгүүдийг тодруулсан. Уг арга хэмжээнд орон нутгаас 2,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Эх хэлний өдрийг тохиолдуулан үндэсний бичгийн уралдааныг соёлын салбарын албан хаагчид дунд зохион	90

	Үндэсний бичиг соёлыг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах					байгуулж 12 албан хаагч, "Тунгаамал" үндэсний бичгийн уралдааныг зохион байгуулж 36 сурагч, 78 төрийн албан хаагчыг оролцуулж, 2,0 сая төгрөг зарцуулсан.	
2.9	<p>Соёлын тухай хуулийн 11.4, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 16.1, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.2</p> <p>Хүчирхийлэл, хорт зуршил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн соён гэгээрлийг дэмжих сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах</p>	Орон нутгийн төсөв	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Хэрэгжүүлсэн арга хэмжээ-2	2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна.	<p>Аймгийн хэмжээнд өрнөсөн “Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй” аяны хүрээнд соёл, урлагаар дамжуулан 10 гаруй нөлөөллийн ажлыг зохион байгуулж, 4 сумын 1200 гаруй иргэдийг хамруулсан.</p> <p>“Монгол гэр-соёлын орон зай”, “Соёлын өдөр” арга хэмжээг 20 гаруй төрлөөр зохион байгуулж 4315 хүүхэд багачууд, иргэдэд соёлын боловсрол олгосон.</p> <p>Аймгийн мэргэжлийн урлагийн байгууллага Саран хөхөө театр “Эвт Мэргэн Өвгөн Эх Чоно хоёрын домог” хүүхдийн жүжгийг сургуулийн өмнөх боловсролын хүүхдүүдэд, “Чандмань Эрдэнэ” хүүхдийн жүжгийг ерөнхий боловсролын сургуулийн 650 сурагчдад үзүүлж хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, бие биенийгээ хүндлэх соёлыг түгээсэн.</p> <p>2024 оны хагас жилийн байдлаар хүчирхийлэл, хорт зуршил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн соён гэгээрлийг дэмжих сургалт, нөлөөллийн 30 гаруй арга хэмжээ зохион байгуулж, 40 гаруй ААН байгууллага, төрийн болон хувийн хэвшилтэй хамтран ажиллаж, 20000 гаруй иргэдийг соён гэгээрүүлсэн.</p>	100
3. УРЛАГ, УРАН БҮТЭЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР							
3.1	<p>Соёлын тухай хуулийн 24,1</p> <p>“GO MONGOLIA” аяны хүрээнд Соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр орон нутгийн брэнд соёл, урлагийн наадмын арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх</p>	Орон нутгийн төсөв	Зохион байгуулсан арга хэмжээ болон оролцогчдын тоо	-	1-ээс доошгүй арга хэмжээг зохион байгуулж, дэмжсэн байна.	<p>Үндэсний өв соёлоо дээдлэн уламжилж, үр хойчдоо өвлүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, “GO MONGOLIA” аяны хүрээнд “Монгол гэр” үзэсгэлэнд “Ноён хутагтын өргөө” халх угсаатны 8 ханатай гэрээр оролцож Монгол гэр барих, буулгах арга ухаан, “Уламжлалт тоглоом наадгай”, “Монголчуудын уламжлалт хувцас, гоёл чимэглэл”, “Тойрон бүжиг” зэрэг хөтөлбөрүүдийг гадаад, дотоодын 12000 гаруй иргэд, хүүхэд багачуудыг сурталчлан ажиллалаа. Үзэсгэлэнгийн арга хэмжээнд Соёлын яамнаас 30,0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 10,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Дорноговь аймгийн соёлын салбар соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, орон нутгийн брэнд онцлог бүхий “Их говийн тэмээ”, “Тэнгэрийн хутагт” фестивалийг зохион</p>	90

						байгуулахаар 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд төлөвлөсөн. “Их говийн тэмээ” фестивалийг цаг агаарын нөхцөл байдал /зуд/-аас шалтгаалан цуцалсан. “Тэнгэрийн хутагт” фестивалийг сүүлийн хагас жилд зохион байгуулахаар төлөвлөсөн.	
3.2	Соёлын тухай хуулийн 24,1 Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2,6,2,3 Орон нутгийн угсаатан, ястны соёлын онцлогт суурилсан үндэсний болон сонгодог жүжиг, концерт, дуулалт жүжгийн бүтээлийг шинээр туурвихад дэмжлэг үзүүлэх.	Улсын болон орон нутгийн төсөв	Уран бүтээлийн тоо	Арга хэмжээ-53, хүрсэн хүний тоо-150000	1-ээс доошгүй шинэ уран бүтээл туурвисан байна.	Орон нутгийн угсаатан, ястны соёлын онцлогт суурилсан “Эвийн эгшиг” уртын дууны дугуйлан, “Болор эгшиглэн” үндэсний хөгжмийн хамтлагийн тоглолтыг 1000 гаруй иргэд, хүүхэд багачуудад хүргэж өв соёл, түүх уламжлалаа сурталчлан, түгээн дэлгэрүүлсэн. Аймгийн Засаг даргаас тоглолт, арга хэмжээнд 10,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. “Саран хөхөө” театр орон нутгийн угсаатан, ястны соёлын онцлогт суурилсан “Шашин урлагийн цэнгүүн”-ийг 200 гаруй сүсэгтэн олонд, “Үзэсгэлэнт говь” говь нутгийн бүжиг дэглээчдийн бүтээлүүдээс бүрдсэн бүжгэн тоглолтыг 400 гаруй иргэдэд толилуулсан. Монголын зохиолчдын “Хурмаст тэнгэр” төвийн 70 жилийн ойн хүрээнд нутгийн уран бүтээлчдийн уран бүтээлийг сурталчлан, олон нийтэд хүргэсэн “Түмэнд түгсэн дуун цадиг” тоглолтыг зохион байгууллаа. Тоглолтыг танхимаар 300 гаруй, цахимаар 4000 гаруй иргэд үзлээ. Хагас жилийн байдлаар шинээр 5 уран бүтээл туурвиж 5750 иргэнд хүргэсэн.	90
3.3	Соёлын тухай хуулийн 24,1 Мэргэжлийн урлагийн байгууллагын урын сан дахь уран бүтээлийг цахим хэлбэрт шилжүүлэн, сан бүрдүүлж, цахим орчинд түгээх, орон нутгийн телевизээр дамжуулан иргэдэд хүргэхэд дэмжлэг үзүүлэх.	Орон нутгийн төсөв	Үзэгчдийн тоо	Арга хэмжээ-5	Урын сан дахь ноот бичвэрийн 50 хувийг цахим хэлбэрт оруулах, уран бүтээлийг цахимжуулж хүн амын 25-аас доошгүй	Тайлант оны эхний хагас жилийн байдлаар “This is love”, “Миний хөөрхөн саран”, “Тэр од”, “Дөрвөн цагийн говь”, “Хайрынхаа төлөө”, “Хоёр ертөнц” зэрэг нийт 7 шинэ уран бүтээлийг мэргэжлийн урлагийн байгууллага “Саран хөхөө” театр урын сандаа бүртгэн авч, шинэ уран бүтээлүүдийг байгууллагын пэйж хуудас болон Youtube хуудсанд байршуулан нийт 10000 гаруй иргэдэд хүргэж 20,0 сая төгрөг зарцуулсан. Урын сан дахь ноот бичвэрийн 60 хувийг цахим хэлбэрт шилжүүлж, цахим орчинд 3 уран бүтээлийг түгээж 10000 хүн үзсэн. Хуучин урын сангийн бүтээлээс 20 уран бүтээлийг цахим хэлбэрт шилжүүлэн, сан бүрдүүлсэн. /бүжиг-6, дууны уран бүтээл-10, драмын жүжиг-4/	90
3.4	Нийтээр тэмдэглэх баярын болон	Орон нутгийн	Арга хэмжээний	-	3-аас доошгүй арга	Салбар дундын хамтын ажиллагааны хүрээнд үндэсний бичиг соёлын баярыг тохиолдуулах 35 дахь удаагийн	100

	<p>тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 41,1, Засгийн газрын 2019 оны 369 дүгээр тогтоол</p> <p>Үндэсний баяр наадмын соёл, урлагийн арга хэмжээний хүрээнд “Дээлтэй Монгол наадам” Монгол сайхан орон” дүрслэх урлагийн үзэсгэлэн, “Монгол бахархал” гэрэл зургийн үзэсгэлэн зэрэг арга хэмжээг зохион байгуулах</p>	Н төсөв	тоо-		<p>хэмжээ зохион байгуулсан байна</p>	<p>номын баярын үеэр “Дээлтэй Монгол” загварын шоуг зохион байгуулж Саран хөхөө театрын уран бүтээлчид монгол өв соёлоо агуулсан үндэсний хувцсаа өмсөж, нэгдсэн жагсаалд оролцож дэд байр эзэллээ. Мөн МССТ-өөс “Дээлтэй Монгол”, “Би зураач” “Гэр” боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэн 200 хүүхдэд музейн боловсрол олгосон.</p> <p>Дэлхийн бүжигчдийн өдрийг угтан “РЕПИЙН ХААН-2024” чөлөөт бүжгийн тэмцээн, Хоёр ертөнц” бүжгийн тоглолтыг 700 гаруй өсвөрийн бүжигчид болон иргэдийг хамруулан зохион байгууллаа.</p> <p>Олон улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулж "Бүсгүй ертөнц" тоглолтыг аймгийн “Говийн уянга” хамтлагтай хамтран зохион байгуулж 350 гаруй иргэдэд толилуулсан.</p> <p>Соёлын салбарын залуучуудын зөвлөлөөс “Аясгалан хөг” ардын дууны оpen mic тоглолт, Төв номын сангаас яруу найргийн оpen mic зэрэг шинэлэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж 200 гаруй иргэнд хүрч ажилласан.</p> <p>Нийтээр тэмдэглэн баярын болон тэмдэглэлт өдрүүдэд 7 арга хэмжээг зохион байгуулж 1450 иргэнд соёлын үйлчилгээ үзүүлсэн.</p>	
3.5	<p>Соёлын тухай хуулийн 24,1 Соёлын яамны стратеги төлөвлөгөөний 6 дүгээр</p> <p>Олон улсын болон бүс нутгийн хэмжээнд зохион байгуулагдах уралдаан тэмцээнд мэргэжлийн уран бүтээлчид, хүүхэд багачуудыг оролцуулахад дэмжлэг үзүүлэх.</p>	Орон нутгийн төсөв	Оролцогчдын тоо-	<p>Үндсэн болон олон улсын 9 уралдаан тэмцээнд уран бүтээлчдийг дэмжсэн.</p>	<p>5-аас доошгүй уран бүтээлчид, хүүхэд багачуудыг дэмжсэн байна.</p>	<p>Өмнөговь аймагт зохион байгуулагдсан Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, хөгжмийн зэмсэг урлаач П.Байгальжавын нэрэмжит “Эгшиглэнт хуур” морин хуурчдын улсын уралдаанд Дорноговь аймгаас төлөөлөн оролцсон “Болор эгшиглэн” хамтлагт 2,3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Уг улсын тэмцээнд тэргүүн байр эзэлсэн.</p> <p>Хүүхэд багачуудад, өсвөр үеийхэнд монгол үндэсний хөгжмийг таниулан сурталчлах, суралцах идэвхийг өрнүүлэх театрын хүний нөөц бүрдүүлэх авьяаслаг хөгжимчдийг тодруулах зорилгоор “Авьяаслаг хөгжимчид” үндэсний хөгжийн анхдугаар уралдааныг 6 сумын 150 гаруй сурагчдыг оролцуулан зохион байгуулж 350 гаруй иргэд үзсэн. Уг уралдаанд 4,0 сая төгрөг зарцуулсан.</p> <p>“Би эстрадын дуучин” Улсын XIX уралдаанд оролцсон Сайншанд сумын хүүхдийн 3 дугаар цэцэрлэгийн сурагчдад 1,0 сая төгрөгийн замын зардлын дэмжлэг үзүүлсэн.</p>	100

						Олон улсын болон бүс нутгийн хэмжээнд зохион байгуулагдсан 3 тэмцээнд 170 гаруй сурагчдыг оролцуулан 8,3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	
3.6	Соёлын тухай хуулийн 24,1 Хүүхдэд зориулсан уран бүтээлийг нэмэгдүүлэхэд орон нутгийн уран бүтээлчдийн шинэ бүтээл, төсөл арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх, сурталчлах.	Улсын болон орон нутгийн төсөв	Уран бүтээлийн тоо	-	2-оос доошгүй шинэ уран бүтээлд дэмжлэг үзүүлж, сурталчилж хамтран ажилласан байна.	Тайлант хугацаанд Ноён хутагт Данзанравжаагийн нэрэмжит Саранхөхөө театраас Э.Нямдуламын зохиол “Эвт Мэргэн Өвгөн Эх Чоно хоёрын домог” хүүхдийн жүжгийг сургуулийн өмнөх боловсролын хүүхдүүдэд, “Чандмань Эрдэнэ” хүүхдийн жүжгийг Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан шинээр найруулан бүтээлээ. Хүүхдийн уран бүтээлийн нэр төрлийг нэмэгдүүлж, насны онцлогт тохирсон уран бүтээлийг толилуулах, соёл, урлагаар дамжуулан хүүхэд багачуудын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэн, төлөвшүүлж, соён гэгээрүүлэх зорилготой хүүхдийн жүжгийг сургуулийн өмнөх насны 250 хүүхэд, ЕБС-ын 300 гаруй сурагчид үзэж сонирхлоо. Замын-Үүд сумын Соёл, спортын ордны “Мини-Отголдой” хүүхдийн театр үе тэнгийн дээрэлхэлт, зан байдал, харьцаа хандлага, хорт зуршлуудаас урьдчилан сэргийлэх сургамжит жүжгийг Айраг, Даланжаргалан, Өргөн, Эрдэнэ сумын 1200 хүүхдүүдэд толилуулж, орон нутгийн уран бүтээлийн тоог нэмэгдүүллээ. Тайлант оны хагас жилийн байдлаар шинээр бүтээсэн 3 уран бүтээлд орон нутгийн төсвөөс 24,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	100
4. СОЁЛЫН ӨВИЙГ ХАДГАЛЖ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР							
4.1	Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 37.4, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 5 дугаар зорилт 5 дугаар арга хэмжээ: Аймгийн хамгалалтад байх түүх, соёлын үл	Улсын болон орон нутгийн төсөв	Гэрээ байгуулсан дурсгалын хувь	Улсын хамгаалалтад орсон 4, Аймгийн хамгаалалтад орсон 14 дурсгалыг иргэн хуулийн этгээдэд гэрээгээр хариуцуулсан	100% гэрээ байгуулсан байна.	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 13-р тогтоолоор батлагдсан "Улсын хамгаалалтад байх түүх соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт"-д Дорноговь аймгаас түүх соёлын үл хөдлөх 6 дурсгал улсын хамгаалалтад бүртгэгдсэн. Тайлант оны эхний хагас жилд Сайхандулаан сумын нутагт орших "Хар хөтлийн палеонтологийн дурсгалт газар", Мандах сумын нутаг дэвсгэрт орших Өлгий хийдийг хариуцуулан хамгаалуулах гэрээ байгуулж аймгийн хэмжээнд улсын хамгаалалтад орсон 6 үл хөдлөх дурсгалыг иргэдэд 100% гэрээгээр хариуцуулан хамгаалууллаа. Тайлант оны хагас жилийн байдлаар аймгийн хамгаалалтад бүхий 14 дурсгалыг иргэн хуулийн этгээдэд гэрээгээр хариуцуулж ажиллалаа.	100

	хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтыг иргэн, хуулийн этгээдэд гэрээгээр хариуцуулна.						
4.2	<p>Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 37.4, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.3.6, Яамны стратеги төлөвлөгөөний 5 дугаар зорилт 3 дугаар арга хэмжээ: Иргэд, сүм хийдэд хадгалагдаж байгаа баримтат өвийг бүртгэлд хамруулна.</p>	Орон нутгийн төсөв	Шинээр нэмж бүртгэсэн баримтат өвийн тоо	2023 онд 55 баримтат өвийг бүртгэсэн	50-аас доошгүй баримтат өвийг шинээр бүртгэсэн байна.	<p>Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Замын-Үүд сумын Гаальд хураагдсан түүх соёлын дурсгалт зүйлсийг Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн шийтгэврээр 35 судар номыг Музей, сургалт судалгааны төвийн сан хөмрөгт шилжүүлэн баримтат өвд бүртгэн авч ажиллалаа.</p> <p>Улаанбадрах сумын Соёл, спортын төв нь уйгуржин монгол бичгээр бичсэн “Гэсэр” тууж, “Үлгэрийн далай” Түвд, Уйгуржин монгол бичгээр хослуулан бичсэн “Шидэт хүүрийн үлгэр” номнуудыг бүртгэж зурагжуулан баримтат өвийн баяжилт хийлээ.</p> <p>Дэлгэрэх сумын Соёл спортын төвөөс МУСТА Морин хуурч Чойн Банзрагчийн 1979 онд бүтээсэн “Баяслын эгшиг” хөгжмийн нот, гар бичмэл, Нанзадын Надмидын 1978 онд бүтээсэн “Гал голомт” (Гурван бүлэг таван үзэгдэлт жүжиг)-ийн гар бичмэл бүтээлүүдийг тус тус баримтат өвийн бүртгэлд хамрууллаа.</p> <p>Тайлант оны хагас жилийн байдлаар 35 ном судар, 5 гар бичмэл бүтээлийг баримтат өвд бүртгэж авлаа.</p>	100
4.3	<p>Соёлын өвийг хамгаалах тухай 16.1.5, 26.1, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолоор баталсан “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам” Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогыг зохион байгуулах.</p>	Улсын болон орон нутгийн төсөв	Тооллогын тайлан	2018 онд явуулсан тооллогын тайлан	Хууль тогтоомжийн дагуу тооллогыг хийж, тайланг ирүүлсэн байна.	<p>Түүх соёлын үл хөдлөх дурсгалын тооллогын бэлтгэл ажлын хүрээнд тооллого зохион байгуулах салбар комиссын бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/03 дугаар захирамжаар 11 хүний бүрэлдэхүүнтэй батлууллаа.</p> <p>Тайлант оны сүүлийн хагас жилд улсын тооллогын ажлыг зохион байгуулахаар төлөвлөсөн.</p>	30
4.4	<p>Соёлын тухай хуулийн 21.1.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 39.3 Соёлын биет бус өвийг</p>	Орон нутгийн төсөв	Дэмжлэг үзүүлсэн өвлөн уламжлагчийн тоо	Бүртгэлтэй өвлөн уламжлагч 54	10-аас доошгүй өвлөн уламжлагчийг сурталчлан	<p>Музей сургалт судалгааны төвийн дэргэдэх “Эвийн эгшиг” уртын дууны дугуйлан, “Увидаст ятга” ятгын дугуйлангийн суралцагчид болон ерөөлч, магтаалч, өвлөн уламжлагчид хамтран ардын язгуур урлагийн тоглолтыг 350 гаруй иргэнд толилууллаа. “Эвийн эгшиг” уртын дууны</p>	100

	өвлөн уламжлагчийг сурталчлан алдаршуулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх.				алдаршуулах ад дэмжлэг үзүүлсэн байна.	<p>дугуйлан 2014 оноос хойш 300 гаруй шавь бэлтгэн гаргасныг үнэлэн, Соёлын яамны "Тэргүүний ардын авьяастан" цол тэмдгээр 10 хүнийг шагнаж, урамшуулахаар болсон. Уг тоглолт, арга хэмжээнд аймаг орон нутгаас 4,4 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>ЮНЕСКО-гийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалтад бүртгэгдсэн "Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл"-ийг сурталчлан таниулах зорилгоор "Монгол гэр" үзэсгэлэн арга хэмжээнд уламжлалт гар урлалын өвлөн уламжлагчдын бүтээл халх угсаатны модон сийлбэртэй их 8 ханатай гэрийг сурталчлан алдаршууллаа. Үзэсгэлэнгээр зочилсон зочдын тоо 10000 гаруй, боловсролын хөтөлбөрт 2000 гаруй хүн хамрагдсан. Тус арга хэмжээг аймгийн Засаг даргын 2024 оны А/393 дугаар захирамжаар 10,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>"Монгол гэр-Соёлын орон зай" хөтөлбөрт соёлын биет бус өвийн уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадам, уриа дуудлагын ай савын төрлүүд болон монгол шатрын тоглоом наадгай, шагайн харваа болон "Найрын дэг ёс"-ыг танилцуулан шатар болон шагайн холбоо, өвлөн уламжлагч нартай хамтран ажиллалаа.</p> <p>Хатанбулаг сумын соёл, спортын төвөөс өвлөн уламжлагч Д.Лувсанбалдангийн аман хууч яриагаар үлгэрийн контент бүтээлгэж алдаршуулах ажлуудыг зохион байгуулж олон нийтэд түгээн, сурталчилж ажилласан.</p> <p>Тайлант оны хагас жилийн байдлаар соёлын салбарын хүрээнд соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдыг алдаршуулах улсын 1, аймаг бүсийн 4, сум орон нутгийн хэмжээний 2, нийтдээ 7 арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.</p>	
4.5	Соёлын тухай хуулийн 21.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 264 дүгээр тогтоол "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестиваль зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	Улс, орон нутгийн төсөв	Фестиваль д оролцсон эсэх Зарцуулсан төсөв	"Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивалийг 2023 онд зохион байгуулсан	Фестивальд орон нутгийн оролцоог хангаж оролцсон байна. Арга хэмжээнд дэмжлэг	"Нүүдэлчин" дэлхийн соёлын фестиваль 8 сард зохион байгуулагдана.	Х.Б

					үзүүлж санхүүжүүлсэ н байна.		
5. СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР							
5.1	<p>Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.4, Засгийн газрын 2022 оны 314 - р тогтоол, Засгийн газрын 2023 оны 481 дүгээр тогтоол.</p> <p>Аймаг, бүс нутгийн онцлогт тулгуурласан соёлын бүтээлч үйлдвэрлэлийн зураглал, стратеги төлөвлөгөөг боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах.</p>	Улс, Орон нутгийн төсөв	Баримт бичиг батлагдсан байна.	-	Батлагдсан төлөвлөгөө - 1 Хэрэгжилтийн тайланг Соёлын яаманд ирүүлсэн байна.	<p>Тайлант оны эхний хагас жилд төрөөс дэмжлэг үзүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл, дэмжих арга хэмжээг батлах тухай Засгийн газрын 2022 оны 314 дүгээр тогтоолыг үндэслэн аймаг, бүс нутгийн онцлогт тулгуурлан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх 4 жилийн (2025-2028) хөтөлбөрийг 20 арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөгөөний төсөл боловсруулсан.</p> <p>Аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа -2” үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өрхийн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжин хөгжүүлэх, орон нутагт үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг нэг цэгээс борлуулах, сурталчлах “Дорноговьд үйлдвэрлэв” бизнес эрхлэгчдийн нэгдсэн төвийг барьж эхэлсэн.</p>	70
5.2	<p>Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.4</p> <p>Хувийн хөрөнгө оруулалтаар соёлын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй иргэн, хуулийн этгээдийн санал санаачилга, бүтээлч үйл ажиллагааг дэмжих, урамшуулах</p>	ОНТ	Иргэн хуулийн этгээдийн тоо	2023 онд нийт 6 арга хэмжээ зохион байгуулсан	5-аас доошгүй иргэн хуулийн этгээдийг дэмжсэн байна.	<p>“Монгол гэр” арга хэмжээний хүрээнд орон нутгийн дэмжлэгтэйгээр 3,0 сая төгрөгийн үнэ бүхий гэрийн тавилга, модон эдлэл, зургийн бүтээлийг орон нутгийн гар урчууд, бүтээлч үйлдвэрлэгчдээс худалдан авч үйл ажиллагааг нь дэмжсэн.</p> <p>Мөн аймгийн төв талбайд зохион байгуулсан “Монгол гэр-Соёлын орон зай” хөтөлбөрийн хүрээнд соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч 4 иргэний бүтээлийг сурталчлан, олон нийтэд танилцуулж, хамтран ажиллалаа.</p> <p>“Ардын уламжлалт гар урлалын ай сав” цахим үзэсгэлэнг 8 өвлөн уламжлагчдийг оролцуулан бүтээж цахимаар 7662 хүн үзсэн.</p> <p>Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч 4 иргэнийг дэмжин ажиллаж, 3 иргэнээс 3,0 сая төгрөгийн бүтээл худалдан авч үйл ажиллагааг дэмжсэн.</p>	90
5.3	Монгол Улсын Засгийн	Орон	Авч	Зөвлөмж	Дүгнэлт- 1	Төрийн хяналт шалгалтын хууль тогтоомжийн дагуу	50

	<p>газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.4</p> <p>Соёл урлагийн байгууллага, концертын танхим, караоке, бар, ресторанд оюуны өмч, зохиогчийн эрхийн талаарх тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж шаардлагатай арга хэмжээг авах.</p>	нутгийн төсөв	хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	хүргүүлсэн Сургалтад хамрагдсан.	2-оос доошгүй арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	<p>Соёлын сайдын 2024 оны 03 сарын 25-ны өдрийн А/137 дугаар тушаалаар соёлын хяналтын улсын ахлах байцаагчаар Соёл урлагийн газрын дарга, улсын байцаагчаар Соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн нар томилогдсон.</p> <p>Орон нутгийн Соёлын хяналтын улсын байцаагчаар Соёл урлагийн газрын холбогдох албан тушаалтнууд томилогдсонтой холбогдуулан соёл урлагийн байгууллага, концертын танхим, караоке, бар, ресторанд оюуны өмч, зохиогчийн эрхийн талаарх хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөө боловсруулсан.</p>	
5.4	<p>Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.4</p> <p>Соёл урлагийн байгууллагуудын мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц (өндөр хурдны интернэт) -ийн өнөөгийн нөхцөл байдлыг үнэлж дүгнэлт гаргах, хүртээмжийг нэмэгдүүлэх.</p>	Улс, Орон нутгийн төсөв	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	-	Дүгнэлт- 1 3-аас доошгүй арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Өндөр хурдны интернетэд холбогдсон соёл, урлагийн байгууллагын тоо 100 хувь	<p>Монгол Улсын Соёлын яамнаас Монголын цахилгаан холбоо ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулсны дагуу аймгийн 10 сумын соёлын төвд шилэн кабель холбосон бөгөөд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар сумдын соёлын төвүүдийг лед дэлгэцтэй болгох, технологийн шинэлэг, дэвшилтэт шийдэл ашиглан соёлын үйлчилгээг нэвтрүүлэх ажлууд хийгдсэн.</p> <p>Соёл урлагийн 14 байгууллага шилэн кабельд холбогдож, хэрэгжилт 77,7%-тай байна.</p>	70
Биелэлтийн хувь							87,3

Соёлын сайд, Дорноговь аймгийн Засаг дарга нарын хооронд байгуулсан гэрээний хоёрдугаар хавсралт

ТӨРИЙН ЧИГ ҮҮРГИЙГ ТӨЛӨӨЛӨН ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ДАГУУ ХЭРЭГЖҮҮЛЭХ СОЁЛЫН САЛБАРЫН БҮТЭЭН

БАЙГУУЛАЛТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг /сая төг/	Санхүүжих дүн /сая.төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин (хэрэгжилт болон тайлбар)	Гүйцэтгэлийн хувь
1	Орон нутагт эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих техник хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн тайлагнаж зардлыг санхүүжүүлнэ	-	-	Барилгын ажлын үе шатанд хяналт тавьсан байдал		Барилга угсралтын ажлын явцад чанарын хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн үр дүнгээр нь санхүүжилтийг олгосон байх	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжүүлэн он дамжин хэрэгжүүлж буй Саран хөхөө театрын барилга, Замын-Үүд сумын Соёл, спортын ордны хэрэгжилтэд хяналт тавих ажлыг гүйцэтгүүлэхээр аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт 25,7 сая төгрөгийн санхүүжилт олгож, ажлын гүйцэтгэлийг сайжруулах үүрэг өгсөн.	70
2	Орон нутгийг төсвийн хөрөнгө оруулалтаар соёл урлагийн байгууллагын барилгад засвар хийж хүчин чадлыг нэмэгдүүлнэ	-	-	Засвар тохижилт хийсэн объект тоо		5-аас доошгүй барилгад засвар тохижилт хийх хүчин чадлыг нэмэгдүүлнэ	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Сайхандулаан сумын соёлын төвийг "Илч дулаан өсөх" компани 208,8 сая төгрөгөөр, Иххэт сумын соёлын төвийг "Чандмань тайж" ХХК 388,7 сая төгрөгөөр, Алтанширээ сумын соёлын төвийг "Мунараконстракшн" ХХК 451,9 сая төгрөгөөр их засварын ажлыг гүйцэтгэж, ажлын гүйцэтгэл 50%-тай явагдаж байна.	90
3	Саран хөхөө театрын барилга, 700 суудал	18,503.10	7,754.71	Гүйцэтгэлээр санхүүжүүлэх дүн	70%	Барилга угсралтын ажлыг бүрэн дуусгана	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 700 хүний суудалтай "Саран Хөхөө" театрын барилга угсралтын ажлыг "Болор-Аграмба" ХХК гүйцэтгэж 2024 оны 10 сарын 01-нд хүлээн авна. "Саран Хөхөө" театрын барилга угсралтын ажилд улсын төсвөөс 8,2 тэрбум, орон нутгийн төсвөөс 1,5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон. Барилгын явц-55%	70
4	Соёл урлагийн ордон 500 суудал /Замын-Үүд сум/	8,347.89	1,677.84	Гүйцэтгэлээр санхүүжүүлэх дүн	80%	Барилга угсралтын ажлыг бүрэн дуусгана	Замын-Үүд сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт улсын төсвийн 7,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 500 хүний суудалтай Соёл урлагийн ордны барилга барих ажлыг "РСТ" ХХК гүйцэтгэж	90

							байна. Барилгыг хүлээлгэн өгөх хугацаа 2024 оны 09 сарын 01 хүртэл сунгасан. Барилгын гүйцэтгэл 90%	
5	Соёлын төвийн барилга /Дэлгэрэх сум/	4,191.90	1,257.57	Гүйцэтгэлээр санхүүжүүлэх дүн	0%	1.Гүйцэтгэгч сонгон шалгаруулна 2. Гүйцэтгэлийг 30 хувьд хүргэнэ	Дэлгэрэх сумын Соёлын төвийн барилгын ажлын зураг, төсөв эцэслэсэн. Гүйцэтгэгч сонгон шалгаруулах шатанд явж байна.	30
6	Соёлын төвийн барилга /Эрдэнэ сум/	3,456.90	1,037.07	Гүйцэтгэлээр санхүүжүүлэх дүн	0%	1.Гүйцэтгэгч сонгон шалгаруулна 2. Гүйцэтгэлийг 30 хувьд хүргэнэ	Эрдэнэ сумын Соёлын төвийн барилгын ажил тендер шалгаруулалтын шатанд явж байна.	30
Биелэлтийн хувь								63,3%